



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 28

Баруун-Урт

Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд
Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, "Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр", түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Монгол улсын " Хог хаягдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг тус тус үгдэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх " Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөрийг нэгдүгээр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


Хоёр. Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ж. Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.



ДАРГА *[Signature]* П. МӨНХЖАРГАЛ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны
04 дүгээр сарын 25 ны өдрийн 28 тоот
тогтоолын 1 дүгээр хавсралт



**“СҮХБААТАР АЙМГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ
САЙЖРУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨР” / 2016-2022 он /**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Хог хаягдлын өнөөгийн байдал:

Сүхбаатар аймаг нь 57 мянган хүн амтай, 16 мянган өрхтэй төв суурин газар дунджаар жилдээ 97 -120 мянган тн хог хаягдал үүсдэгээс 80% нь ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал, 10% нь барилгын хог хаягдал, 8% нь эмнэлгийн болон аюултай, бусад хог хаягдал эзэлдэг бөгөөд өдөрт нийт 23 тн хог хаягдлыг ландшагийн аргаар дарж устгаж байна. Хог хаягдлын бүтцийн хувьд өвлийн улиралд нийт хог хаягдлын 49-50%-ийг үнс, нүүрсний хог эзэлдэг.

Хог хаягдлын бүтэц

Хог хаягдлын бүтэц	Орон сууц %	Гэр хороолол %	Албан байгууллага %	Гудамж, талбай %	Эмнэлэг %	Нийт %
Цаас	6,66	1,95	3,66	0,56	0,10	12,92
Шил	2,96	2,5	1,5	0,31	0,2	6,39
Метал	0,17	0,92	0,34	0,5	0,2	2,5
Хуванцар	5,1	2,7	2,92	0,44	0,5	11,37
Бусад органик	13,96	8,1	7,24	8,56	0,18	30,5
Бусад органик бус	1,89	32,60	1,37	0,67	0,3	36,51
Аюултай	0,2	0	0	0	0,8	0,26
Нийт	31,88	48,32	16,69	2,69	0,42	100%

Өнөөгийн байдлаар аймгийн хэмжээнд хог хаягдал гаргагч эх үүсвэр дулааны станц-1, нам даралтын уурын зуух- 187, тээврийн хэрэгсэл- 6183, шатахуун түгээх станц-31, айл өрхийн жижиг зуух-7239, хувиараа бизнес эрхлэгч иргэн-2278, аж ахуйн үйл ажиллага явуулж байгаа малчин өрх- 8033, хүнсний худалдаа, үйлчилгээний газар -208, үйлдвэр, цех-23, албан байгууллага, аж ахуй нэгж-600 гаруй байна. Цаашид хүн амын тоо өсөхийн хэрээр төв суурин газруудын нягтрал ихсэж, төрөл бүрийн бүтээгдэхүүний хэрэглээ, сав баглаа боодол нэмэгдэж, үйлдвэржилт, барилгажилт өдөр ирэх тусам улам эрчимтэй явагдах хандлагатай байна.

Санхүүгийн тогтолцоо: Орон нутгийн төсөв, айл өрх, ААН-ийн хог гаргасны төлбөрөөр хог хаягдлын менежментийн асуудлыг санхүүжүүлэн ажиллаж байна.

Хог хаягдлын хураамжийн хэмжээг Сумын ИТХ-аар тогтоож орон сууц, гэр хорооллын айл өрхөөс 1000-2500 төгрөг, аж ахуй нэгж байгууллагаас 15000-30000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байгаа бөгөөд Хог хаягдлын хураамж “Татварын тухай хууль”-иар татварын нэг төрөл болсонтой холбогдуулан татвар бүрдүүлэлтийн журмаар зохион байгуулж эхлээд байна. Тухайлбал: Баруун-Урт

сум хог хаягдлын хураамжаас 2014 онд 55 сая төгрөг, 2015 онд 76 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Бусад сумдын хувьд сумын ИТХ-аар хог хаягдлын хураамжаа шинэчлэн тогтоож байгаа бөгөөд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх асуудал хүлээгдэж байна.

Хог хаягдлын хэмжээ жил ирэх тутам өсөн нэмэгдэж, шинж байдал нь хор, аюултай болж байгаа өнөө үед хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, хаягдлыг олон Улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргаар устгах асуудлыг зохих шаардлагын түвшинд хүргэх, барилгын болон аюултай хог хаягдлын төвлөрсөн цэгүүд байгуулах, ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, дахин ашиглах буюу 3R /reduce-багасгах, recycle-дахин ашиглах, reuse-дахин боловсруулах/-зарчмаар хог хаягдлын хэмжээг багасгах, байгалийн нөөцийг хэмнэх, хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлэх хэрэгцээ шаардлага бидний өмнө тулгараад байна.

Энэ бүх асуудлыг шийдвэрлэхэд санхүүгийн эх үүсвэр, хүн хүчний нөөц, дадлага туршлага, техник тоног төхөөрөмжийн хүрэлцээ, хангамж ихээхэн дутагдалтайгаас гадна иргэдийн экологийн боловсрол дутмаг, хаягдлаар бизнес эрхэлж буй хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг төрөөс санхүүгийн болон тодорхой бодлогоор дэмжихгүй байгаатай холбоотой гэсэн шүүмжлэл, дүгнэлт гарч байсан.

Хог хаягдлын цуглуулалт тээвэрлэлт:

Аймгийн хэмжээнд нийт 29 хог тээврийн авто машин үйлчилж байгаа бөгөөд сумдын ЗДТГ нь иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хог тээвэрлэлт цуглуулалтыг гүйцэтгүүлж байна. Аймгийн хэмжээнд 5 сум ОНӨҮГ-тайгаар хог хаягдлын асуудлыг зохицуулан ажиллаж байна. Баруун-Урт сумын хог хаягдлын цуглуулалт тээвэрлэлтийн ажлыг Сүхбаатар-Тохижилт үйлчилгээ ОНӨҮГ хариуцан ажиллаж байна. Тус газар нь 2010 онд байгуулагдсан бөгөөд нийт 32 ажилтан ажиллагсадтайгаар айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хог хаягдлыг зөөж тээвэрлэх, нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх, нохой муур устгах, бохир соруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээг тус газрын үйлчлэгч нар хариуцан ажиллаж байгаа бөгөөд нэг үйлчлэгчид 7857 м2 талбай ноогдож байгаа бөгөөд 55000 м2 талбайг байнгын цэвэрлэгээтэй байлгаж байна. Хог тээвэрлэлтийн хувьд аж ахуй нэгж байгууллага, орон сууцны хог хаягдлыг тусгай зориулалтын 1 машин 7 хоногт 6 удаа, гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг 6 машин сард 1 удаа ачиж, ангилан ялгалтгүйгээр хог хаягдлын төвлөсөн цэгт зөөж тээвэрлэн өдөрт дунджаар 23 тн хог хаягдлыг дарж устгаж байна. Өмнөх онуудтай харьцуулахад хог зөөврийн автомашины тоо нэмэгдэж, хог зөөвөрлөх үйл ажиллагаа боловсронгуй болсон байна. Сүхбаатар-Тохижилт үйлчилгээ ОНӨҮГ нь одоогийн байдлаар Мицибуши Кант, Бага оврын трактор TAISAN, Тусгай зориулалтын машин СО-440, ЗИЛ-130, 2010 онд Ковш LJ-933L, Мазда гэсэн 9 машинтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Хог хаягдлын ачилт, тээвэрлэлт, дарж, устгалтын байдал

Он	Хогийн сав		Хог хаягдлын ачилт /тн/				Нийт тээвэрлэсэн хог хаягдал /тн/
	Шинээр тавьсан	Засварласан	Орон сууцнаас	Гэр хорооллоос	Албан газар, ААН-ээс	бусад	
2008			3360	12440	1680	4720	22200
2009			1186	13470	5145	5292	25093

2010			7142	8725	4200	1900	21967
2011	25		500	24000	120	1150	27770
2012	50		929	8451	21478	4759	35617
2013	100		15102	68806	1946	3203	89057
2014	191		6712	51050	6933	19347	98034
2015	162		20704	38852	15740	11703	86999

Төвлөрсөн хогийн цэг: Аймгийн хэмжээнд нийт зориулалтын 13 төвлөрсөн хогийн цэг /506 га/ ажиллаж байгаагаас Баруун-Урт сумын төвд ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг хүлээн авах 460 га талбай бүхий 1 цэг ажиллаж байна. Уг хогийн цэг нь 1979 оноос хойш үүссэн Баруун-Урт сумын төвөөс баруун урагш 3 км –т орших бөгөөд 2010 онд улсын төсвийн 137 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар тохижуулах ажлыг гүйцэтгэсэн. Төвлөрсөн цэгийг Сүхбаатар-Тохижилт үйлчилгээ ОНӨҮГ хариуцан айл өрх, аж ахуй нэгж байгууллагаас гарах хог хаягдлыг хүлээн авч хөрсөөр булаах ажлыг гүйцэтгэж байна.

❖ Эрүүл мэндийн салбарын хог хаягдал

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах АНЭ, өрх сум, хувийн хэвшлийн эмнэлгийн халдвар хяналтын 18 баг ажиллаж сав баглаа боодлын хаягдал, шингээгч бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас гэх мэт аюултай хог хаягдал гаргадаг бөгөөд эдгээр хог хаягдлыг 3 ангилан хүлээн авч автоклавд ариутгаж Тохижилт Үйлчилгээ ОНӨҮГ-тай гэрээ байгуулан зөөвөрлөн хаядаг байна. Тохижилт Үйлчилгээ ОНӨҮГ нь нэгдсэн хогийн цэгт аюултай хог хаягдлыг зориулалтын бус байгууламжинд шатаах аргаар устгаж байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.

2015 онд халдвартай хог 447,976 кг, аюулгүй хайрцаг 31215 кг гарсан бөгөөд зохих журмын дагуу устгасан байна. Аюултай хог хаягдлын менежментийн хувьд нийт нэгжийн 55 хувь нь түр хадгалах байртай, 42 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангасан булаах цэгтэй болсон байна.

Уул уурхайн болон бусад аюултай хог хаягдал:

Уул уурхайн хувьд хамгийн их химийн бодис, аюултай хог хаягдал хэрэглэдэг Монгол Хятадын хамтарсан Төмөртэйн цайрын баяжуулах үйлдвэр байна. Уг үйлдвэр нь магадлан итгэмжлэгдсэн лабороторитой, тэсэрч дэлбэрэх бодис, баяжуулах регинтүүд тус тусдаа агуулах складтай, хууль дүрмийн дагуу ажиллаж байгаа болно. Уг уурхайгаас аюултай хог хаягдал сав баглаа боодлоос жилд 1400 ш, ашиглагдахгүй болсон машин механизм, тэдгээрийг засварлах үйл ажиллагаанаас тосны шүүр 38 ш, гидрын шингэн 90 л, тосны хаягдал 480 л тус тус гарч байгаль орчныг бохирдуулж хуримтлагдаж байна.

Дулааны станц: Тус аймаг нь 2013 онд дулааны станцтай болсон ба эдгээрээс жилд 50 тн үнс гарч хогийн цэгт ачигдаж байна. Мөн хаягдал ус цэвэрлэх байгууламжаас үүссэн хортой лаг жилд 5 тн гарч байна. Сумдын хувьд уурын зуухнаас 1,889 тн үнс, зуухны цэвэрлэгээнээс үүсэх хортой бодис агуулсан шингэн лаг 519 м3, тосны шүүр 457 м3, асбест бүхий тоормосны жийргэвч наклад 901 м3 тус тус гарч байна.

Дорнод бүсийн эрчим хүчний систем ХХК-ны салбараас шингэн түлшний хаягдал полихлорт бифенил агуулсан хаягдал жилд 50 л гарч байна.

1.2 Хөтөлбөрийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага:

Монгол улсын үндсэн хуульд Монгол улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалах эрхтэй гэж заасан байдаг. Үүнтэй холбогдуулан 1999 оны Засгийн газрын 50 дугаар тогтоолоор “Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг батласан бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа 2010 онд дууссан.

Энэхүү дэд хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэслэл нь 2014 онд Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр, 2015 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Засгийн газраас батласантай холбогдуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх мөн “Хог хаягдлын тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн болно.

Иймд энэхүү дэд хөтөлбөрийн хүрээнд хог хаягдлын менежментийг эрхлэн гүйцэтгэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чадавхыг сайжруулах, хог хаягдлыг боловсруулах, устгахад шинжлэх ухаан, технологийн дэвшлийг аль болох өргөн ашиглах, гадаадын дэвшилттэй арга технологиудыг өөрийн орон нутгийн онцлогт нийцүүлэн нутагшуулан нэвтрүүлэх, олон нийтийн оролцоо, зөв дадал, ухамсрыг төлөвшүүлэхийг сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэх, эдгээр зорилтыг дэмжсэн эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх замаар хог хаягдлаас үүдэлтэй хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлын шинэ менежментийг нэвтрүүлж, хэвшүүлэх, 3R /хог хаягдлын хэмжээг бууруулах, эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, / зарчмийн талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Ногоон хөгжлийн бодлого, Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Сүхбаатар аймгийн хөгжлийн хөтөлбөр, Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр зэргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг цогцоор тодорхойлох нь “Сүхбаатар аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр”-ийг боловсруулах үндэслэл болсон болно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр улсын хэмжээнд хог хаягдлын зохистой менежментийн эхлэл тавигдах ба төв суурин газарт эрүүл ахуйн шаардлага хангасан төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа жигдэрч, нийт хог хаягдлын 10-оос доошгүй хувийг эргүүлэн ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар дахин боловсруулах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадалд хэвших, хог хаягдлын урсгалын статистик, цахим мэдээллийн сантай болохоос гадна аюултай хог хаягдал хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх чадавх бүрдсэн байна.

Сүхбаатар аймгийн “Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр” нь нийтлэг үндэслэл, хөтөлбөрийн зорилго, зорилтууд, баримтлах зарчим, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт гэсэн 6 бүлгээс бүрдэх бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үндсэн тэргүүлэх 5 зорилт, 30 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр боловсрууллаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

2.1. Нөөцийн үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээ, технологийг дэмжин хаягдлыг бууруулж, байгаль орчинд хал багатайгаар зайлуулах, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хатуу хог хаягдлын зохистой менежментийг төлөвшүүлж, цэвэр эрүүл орчин бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг шийдвэрлэнэ:

2.2.1. хог хаягдлын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгож хэрэгжилтийг сайжруулах, хариуцлага, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх;

2.2.2. үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, хэмнэх замаар хог хаягдлыг бууруулах болон хаягдалгүй дэвшилтэт технологийг дэмжих, үйлдвэрлэлийн хог хаягдлын зохистой менежмент, хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

2.2.3. аюултай хог хаягдлын менежментийг сайжруулж байгаль орчинд хал багатайгаар зайлуулах чадавхийг бүрдүүлж, аюултай хаягдал хуримтлагдахаас сэргийлэх;

2.2.4. хүн амд ногоон хэрэглээний соёл, хог хаягдлыг ангилан ялгах, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэх замаар амьдралын тав тухтай орчин бүрдүүлэх;

2.2.5. хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, эрчим хүч гаргах зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг бууруулах.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. Сүхбаатар аймгийн “Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр”-ийг монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, ногоон хөгжлийн бодлого, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн хөтөлбөрүүд, нийгэм, эдийн засаг, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй нягт уялдаатай харилцан зохицсон байдлаар хэрэгжүүлэх;

3.1.2. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаа, түншлэлд тулгуурлах;

3.1.3. Хаягдлаар бизнес эрхлэгч жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих;

ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Хөтөлбөрийн 2.2.1-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1 Засгийн газраас батласан аргачлалын дагуу хог хаягдлын нормативыг тогтоож, холбогдох судалгааг хийн, уг аргачлалыг мөрдүүлнэ.

4.1.2 Хог хаягдлыг ангилах, цуглуулах, эргүүлэн ашиглах, устгах, санхүүжүүлэх нийтлэг журамыг АИТХ-аар батлуулж мөрдөх

4.1.3 Хог хаягдлын менежментийн тогтвортой санхүүжилтийн орчин бий болгон, хог хаягдлын үйлчилгээний төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлэн, хууль тогтоомжийн дагуу зарцуулах

4.1.4 Хог хаягдлын тооллого явуулж бүртгэлжүүлэн, мэдээллийн цахим сан бүрдүүлж хог хаягдлын хэмжээ, урсгалыг байнгын хяналттай болгох;

4.1.5 Хог хаягдлын зохистой менежментийн тогтолцоог бүрдүүлэх, үйлдвэрлэгч нь бараа бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг эргүүлэн татаж ашиглах, хариуцлага хүлээлгэх, хог хаягдлыг бууруулах эдийн засгийн хөшүүрэг бий болгох

4.1.6 Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах

4.1.7 Хог хаягдлын менежмент хариуцсан нэгжүүдийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, гадаадын болон дотоодын сургалтад хамруулж мэргэшүүлэх

4.2. Хөтөлбөрийн 2.2.2-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1 Үйлдвэрлэл эрхлэлтээс гарах хатуу хог хаягдлыг хянах, байгаль орчинд халгүй арга технологиор зайлуулах

4.2.2. Нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, хэмнэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх замаар хог хаягдлыг бууруулах, хаягдалгүй дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжих;

4.2.3 Хог хаягдлыг бууруулах шинэ арга барил, дэвшилтэд технологи, тэргүүний арга ажиллагаа, аргуудаас суралцах, шинэ технологи нэвтрүүлэхэд донор орон, олон улсын байгууллагуудын дэмжлэгийг авах;

4.2.4 Хог хаягдлын асуудал хариуцсан нэгжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр байгуулж мэргэшүүлэх, хүн хүч, зохион байгуулалт техник тоног төхөөрөмж материаллаг баазын хувьд бэхжүүлэх

4.2.5. хог хаягдал, хорт бодисын ялгарлаас үүдэлтэй орчны бохирдлыг хянах хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, шинжлэх лабораторийн чадавхийг бэхжүүлж хүрээлэн байгаа орчны чанарын бодит мэдээлээр хангагдах.

4.3. Хөтөлбөрийн 2.2.3-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1 Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулна.

4.3.2 Аюултай хог хаягдлыг түр хадгалах зориулалтын байгууламжийг төвлөрсөн хогийн цэгт байгуулна.

4.3.3 Сумдын эмнэлгийн аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх, саармагжуулан түр хадгалах, устгах зориулалтын байгууламжтай болгоно.

4.3.4 Аюултай хог хаягдлын бүртгэл судалгааг хийж, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

4.3.5 Химийн бодисын хор хөнөөлийн талаар иргэдэд тайлбарлан таниулах ажлыг төв, орон нутагт зохион байгуулна.

4.3.6. Аюултай хог хаягдлын талаарх хуулийн хэрэгжилтийг хангах менежментийн чадавхийг бэхжүүлж, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүний хэрэглээнд хяналт тавих.

4.4. Хөтөлбөрийн 2.2.4-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, зориулалтын уут сав хэрэглэх, хогийн цэгт хаях зэрэг дадал хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа өргөнөөр явуулах, иргэдийн санал, санаачилгыг дэмжих;

4.4.2 Хог хаягдлыг бууруулах, амьдрах орчноо цэвэрлэж тохижуулах чиглэлээр орон нутгийн засаг захиргааны зүгээс нийтийг хамарсан компани ажлуудыг зохион байгуулах;

4.4.3. Хот, суурин газар бүрт эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн цэг байгуулах, тохижуулах

4.4.4 Аялал жуулчлалаар явж байгаа иргэдэд ил задгай хог хаягдал хаяхгүй байх талаар мэдээлэл сурталчилгаа тогтмол хийж, хөдөө орон нутгийн зам дагуу хог хаяхыг хориглосон тэмдэгжүүлэлт санамж, самбар байрлуулах

4.4.5 ЕБС-иудын дунд бүлгийн хичээлийн программд “Хог хаягдлын менежмент” сэдэвт хичээлийг тусгаж оруулах

4.4.6 Хог хаягдлыг бууруулахад орон нутгийн иргэд, байгаль хамгаалах чиг үүрэг бүхий иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах

4.4.7 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгадаг тогтолцоог нэвтрүүлэх, хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах, устгах, бага оврын үйлдвэрийг аймгийн төвд хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах

4.5. Хөтөлбөрийн 2.2.5-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.5.1. Бараа бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг үйлдвэрлэгч эргүүлэн татаж ашиглах, дахин боловсруулах тогтолцоог нэвтрүүлэх

4.5.2. Хог хаягдлыг дахин боловсруулах, эрчим хүч гаргах, бордоо, зам талбай, барилгын материал үйлдвэрлэх зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгох үйл ажиллагааг дэмжих

4.5.3 Хаягдлаар байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг үйлдвэрүүдийг байгуулахыг дэмжих

4.5.4 Хөл газрын хог ургамалтай тэмцэх, энэ хүрээнд хогийн ургамлаар компост хийж органик бордоо үйлвэрлэх арга технологийг дэмжиж түгээн дэлгэрүүлнэ

4.5.5 Компанийн нийгмийн хариуцлагыг өндөржүүлж, үйлдвэрлэгчид хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, үйлдвэрлэл дээр нь бууруулах, импортлогчид олон дахин ашиглагдах бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, өөрсдийн нийлүүлж байгаа бараанаас гарах хог хаягдлын менежментийг шийдэх, хариуцлага хүлээх чиглэлээр эрх зүйн зохицуулалт бий болгож хэрэгжүүлэх

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа:

Хөтөлбөрийг 2016-2022 онд хэрэгжүүлнэ.

5.1.1. Хог хаягдлын менежментийг сайжруулах эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, эдийн засгийн чадавхыг сайжруулна;

5.1.2. Хог хаягдлын менежментийг сайжруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;

5.1.3. Иргэдэд тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн талаарх ойлголтыг төлөвшүүлэх замаар хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэмэгдүүлж зөв дадал заншил, ухамсар, сэтгэлгээний төлөвшлийг бий болгоно;

5.1.4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд төгсгөлийн үнэлгээ хийнэ;

5.2. Хөтөлбөрийн санхүүжилт:

- 5.2.1. Улсын болон орон нутгийн төсөв
- 5.2.2. Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж
- 5.2.3. Хувийн хэвшлийн байгууллагаас гаргах хөрөнгө
- 5.2.4. Хог хаягдлын үйлчилгээний сан
- 5.2.5. Бусад эх үүсвэр

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

6.1. Хөтөлбөр хэрэгжсэнээр хог хаягдлын зохистой менежментийн эхлэл тавигдаж, хот суурин газарт эрүүл ахуйн шаардлага хангасан төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа жигдэрч, нийт хог хаягдлын 10-оос доошгүй хувийг эргүүлэн ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар дахин боловсруулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшиж, хог хаягдлын урсгалын статистик мэдээ, цахим сан бүрдүүлэх, аюултай хог хаягдал хуримтлагдахаас сэргийлэх чадавх бүрдсэн байна.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож, 2015 оны тоон мэдээллийг суурь болгон авч үзнэ:

Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь үзүүлэлт	Хүрэх түвшин
		2015 он	2022 он
Дахин боловсруулсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хог хаягдлын хэмжээ	хувь	0	10%
Зориулалтын бус хогийн цэгийн тооны бууралт	тоо, га	14, 23	0
Жилд үүсэж байгаа хатуу хог хаягдлын хэмжээ, бууралт хувиар /%/,	мян,тн	70-80	50-60
Ангилан ялгасан хогийн хэмжээ / хувь/	хувь	2	10
Хог боловсруулах үйлдвэрийн тоо;	тоо	0	1-2
Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилан ялгаж, халдваргүйжүүлэн устгасан хогийн хэмжээ /хувь/	хувь	55%	80%
Тусгай зориулалтын болон ахуйн хог тээврийн машины тоо;	тоо	29	60
Эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн цэг	тоо	0	13

---oOo---



**“СҮХБААТАР АЙМГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ / 2016-2022 он /**

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хамтран ажиллах байгууллага	Шалгуур үзүүлэлт	Хөрөнгийн Эх үүсвэр
Зорилт 1. Хог хаягдлын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгож хэрэгжилтийг сайжруулах, хариуцлага, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх					
1.1	Засгийн газраас батласан аргачлалын дагуу хог хаягдлын нормативыг тогтоож, холбогдох судалгааг хийн, уг аргачлалыг мөрдүүлнэ.	2016-2017	Сумдын засаг дарга, ИТХ	Хог хаягдлын хураамжийн хэмжээ тогтоогдоно.	-
1.2	Хог хаягдлыг ангилах, цуглуулах, эргүүлэн ашиглах, устгах, санхүүжүүлэх нийтлэг журамыг АИТХ-аар батлуулж мөрдөх	2017	Холбогдох байгууллагууд АИТХ	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангадана.	-
1.3	Сум бүр хог хаягдлын үйлчилгээний төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлж хууль тогтоомжийн дагуу зарцуулах	2017-2022	Сумын ЗДТГ ИТХ Татварын хэлтэ	Хог хаягдлын үйлчилгээний хураамж бүрдүүлэлт боловсронгуй болох	-
1.4	Хог хаягдлын тооллого явуулж бүртгэлжүүлэн, мэдээллийн цахим сан бүрдүүлж хог хаягдлын хэмжээ, урсгалыг байнгын хяналттай болгох;	2017	БОАЖГ Сумдын ЗДТГ	Нэгдсэн бүртгэл хөтлөнө.	Улс, орон нутгийн төсвөөс
1.5	Хог хаягдлын зохистой менежментийн тогтолцоог бүрдүүлэх, үйлдвэрлэгч нь бараа бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг эргүүлэн татаж ашиглах, хариуцлага хүлээлгэх, хог хаягдлыг бууруулах эдийн засгийн хөшүүрэг бий болгох	2016-2022	Бүх шатны Засаг дарга	Хог хаягдлын менежмент боловсронгуй болсон байна.	Орон нутгийн төсвөөс
1.6	Төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэхийг дэмжинэ.	2016-2022	Бүх шатны засаг дарга	Үйлчилгээний чанар сайжирч, ажлын байр нэмэгдэнэ.	
1.7	ТХГН, түүний орчны бүс дэх аялал жуулчлал эрхлэгчид хоорондоо нөхөрлөлийн холбоо үүсгэн хог хаягдлын дундын сан байгуулж, түүгээр хог хаягдлын асуудлаа шийдвэрлэдэг болгоно.	2016-2022	БОАЖГ Бүх шатны засаг дарга Хувийн хэвшил	Аялал жуулчлалын салбарын хог хаягдлын менежмент сайжрана.	Хувийн хэвшлээс
1.8	Хог хаягдлын менежмент хариуцсан нэгжүүдийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, гадаадын болон дотоодын сургалтад хамруулж мэргэшүүлэх	2016-2022	БОНХЯ АЗДТГ БОАЖГ	Хүний нөөцийн бэхжүүлсэн байдал, түвшингээр	Төсөл хөтөлбөр

103

1.9	Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах	2016-2022	БОНХАЖЯ БОАЖГ Сумын ЗДТГ	Урамшуулалын тогтолцоо бий болсон байх	Улсын болон орон нутгийн төсвөөс
Зорилт 2. Үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, нөөц түүхий эдийн зарцуулалтыг багасгах, хэмнэх замаар хог хаягдлыг бууруулах болон хаягдалгүй дэвшилтэт технологийг дэмжих, үйлдвэрлэлийн хог хаягдлын зохистой менежмент, хяналтын тогтолцоог бүрдүүлэх					
2.1	Үйлдвэр эрхлэлтээс гарах хатуу хог хаягдлыг хянах, байгаль орчинд халгүй арга технологиор зайлуулах	2016-2022	БОНХАЖЯ Аймгийн Засаг дарга Холбогдох байгууллагууд	Үйлдвэрээс гарах хог хаягдлын хяналт сайжрах	Улсын болон орон нутгийн төсөв
2.2	Сум бүр хог хаягдлын төвлөрсөн цэгээ тохижуулах, байнгын харуул хамгаалалт, хашаажуулах ажлыг зохион байгуулах	2016-2022	Сумын ЗДТГ	Харуул хамгаалалттай хашаа хайстай болсон эсэх	Орон нутгийн төсвөөс
2.4	Хог хаягдлыг бууруулах шинэ арга барил, дэвшилтэд технологи, тэргүүний арга ажиллагаа, аргуудаас суралцах, шинэ технологи нэвтрүүлэхэд донор орон, олон улсын байгууллагуудын дэмжлэгийг авах;	2016-2022	БОНХАЖЯ, АЗДТГ, БОАЖГ, Сумдын ЗДТГ	Донор орон, олон улсын байгууллагуудаас авсан дэмжлэгийн тоо, арга технологи	Төсөл хөтөлбөр
2.5	Хог хаягдлын асуудал хариуцсан нэгжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр байгуулж мэргэшүүлэх, хүн хүч, зохион байгуулалт техник тоног төхөөрөмж материаллаг баазын хувьд бэхжүүлэх	2014-2017	БОНХАЖЯ БОАЖГ, АЗДТГ Засаг дарга нар	Хувийн хэвшлийн тоо, материалаг бааз нэмэгдэх	Улсын болон орон нутгийн төсөв
2.6	Нийтийн эзэмшлийн гудамж талбай, болон аж ахуй нэгж байгууллагын орчинд хог хаягдлын сав, санамж самбар зэргийг хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулах	2014-2020	БОНХАЖЯ БОАЖГ, Сумын Засаг дарга	Хог хаягдлын савны тоо, санамж самбарын тоо нэмэгдсэн байх	Орон нутгийн төсөв
2.7	Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	2017-2018	БОАЖГ Баруун-Урт сумын Засаг дарга	Төвлөрсөн хогийн цэг БОМТ-тэй ажиллана.	Орон нутгийн төсөв
Зорилт 3. Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулж байгаль орчинд хал багатайгаар зайлуулах чадавхийг бүрдүүлж, аюултай хаягдал хуримтлагдахаас сэргийлэх					
3.1	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулна.	2016-2022	Аймгийн ЭМГ Бүх шатны засаг дарга	Аюултай хог хаягдлын менежмент сайжрана.	Орон нутгийн төсөв, төсөл

					хөтөлбөр
3.2	Аюултай хог хаягдлыг түр хадгалах зориулалтын байгууламжийг төвлөрсөн хогийн цэгт байгуулна.	2018-2020	Аймгийн ЭМГ Аймгийн засаг дарга	Аюултай хог хаягдлын эрсдэл, тархалт буурна.	Улс, орон нутгийн төсөв
3.3	Сумдын эмнэлгийн аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх, саармагжуулан түр хадгалах, устгах зориулалтын байгууламжтай болгоно.	2017-2022	Аймгийн ЭМГ Сумын ЗДТГ	Аюултай хог хаягдал байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөлөл буурна.	орон нутгийн төсөв
3.4	Аюултай хог хаягдлын бүртгэл судалгааг хийж мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт үнэлгээ хийнэ.	2016-2018	Холбогдох байгууллагууд Сумын Засаг дарга	Аюултай хог хаягдлын нэгдсэн мэдээлэлтэй болно.	Орон нутгийн төсөв
3.5	Химийн бодисын хор хөнөөлийн талаар иргэдэд тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулна.	2016-2022	Бүх шатны засаг дарга	Иргэд тодорхой ойлголттой болно.	Орон нутгийн төсөв
3.6	Сумдын эмнэлгийн аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх, саармагжуулан түр хадгалах, устгах зориулалтын байгууламжтай болгоно.	2016-2022	Аймгийн ЭМГ Сумын ЗДТГ	Аюултай хог хаягдлын эрсдэл, тархалт буурна.	Орон нутгийн төсөв
3.7	Аюултай хог хаягдлын талаарх хуулийн хэрэгжилтийг хангах менежментийн чадавхийг бэхжүүлж, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй импортын бараа, бүтээгдэхүүний хэрэглээнд хяналт тавих.	2016-2022	Холбогдох байгууллагууд Бүх шатны засаг дарга	Иргэд тодорхой ойлголттой болж хүн амын эрүүл мэнд хүрээлэн буй орчны эрсдэл буурна.	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр
Зорилт 4. Хүн амд ногоон хэрэглээний соёл, хог хаягдлыг ангилан ялгах, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэх замаар амьдралын тав тухтай орчин бүрдүүлэх					
4.1	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын уут сав хэрэглэх хогийн хогийн цэгт хаях зэрэг дадал хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгаа өргөнөөр явуулах, иргэдийн санал, санаачлагыг дэмжих	2016-2022	Холбогдох байгууллагууд Сумын Засаг дарга	Экологийн мэдлэг олгож, цэвэр эрүүл орчин бүрдүүлэхэд оролцоог хангана.	Орон нутгийн төсөв
4.2	Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага бүр орчноо хог хаягдалгүй, цэвэр байлгахын төлөө хөдөлгөөн өрнүүлж түүнийг хэвшил болгон мөрдүүлэн "Цэвэр орчин" аяныг уламжлал болгон зохион явуулж байх /	2016-2022	Холбогдох байгууллагууд Сумдын ЗДТГ БОАЖГ	Хог хаягдлын хэмжээ буурсан байх	Орон нутгийн төсөв
4.3	Аялал жуулчлалаар явж байгаа иргэдэд ил задгай хог хаягдал хаяхгүй байх талаар мэдээлэл сурталчилгаа тогтмол хийж, хөдөө орон нутгийн зам дагуу хог хаяхыг хориглосон тэмдэгжүүлэлт санамж, самбар байрлуулах	2016-2022	Сумын ЗДТГ ТХГН-ийн захиргаа	Хяналтгүй хог хаягдлын тархалт буурна.	Орон нутгийн төсөв

4.4	ЕБС-иудын дунд бүлгийн хичээлийн программд "Хог хаягдлын менежмент" сэдэвт хичээлийг тусгаж оруулах	2017-2018	АЗДТГ БОАЖГ БСГ	Хог хаягдлын талаарх боловсрол сайжирсан	-
4.5	Хог хаягдлыг бууруулахад орон нутгийн иргэд, байгаль хамгаалах чиг үүрэг бүхий иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	2016-2022	БОАЖГ БОИЗ Хувийн хэвшил	Олон нийтийн оролцоо сайжрах	Орон нутгийн төсөв
4.6	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгадаг тогтолцоог сумын төвүүдэд үе шаттай нэвтрүүлж ангилан ялгах цэг байгуулах;	2016-2022	БОНХАЖЯ БОАЖГ Сумын Засаг дарга	Эх үүсвэр дээр нь ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ тн/жил	Улсын болон орон нутгийн төсөв
4.7	Хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах, устгах, бага оврын үйлдвэрийг аймгийн төвд байгуулах судалгаа, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах;	2016-2018	АЗДТГ БОАЖГ Баруун-Урт сумын ЗДТГ	Жилд буурч байгаа хог хаягдлын хэмжээ, хувиар %/;	Улсын болон орон нутгийн төсвөөс
Зорилт 5. Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, эрчим хүч гаргах зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг бууруулах					
5.1	Дахин ашиглах боломжтой шилэн лонхыг худалдааны төвүүдээр дамжуулан эргүүлэн авч, оронд нь хөнгөлөлтийн оноо цуглуулдаг тогтолцоог нэвтрүүлэх	2017-2022	Хувийн хэвшил Сумын Засаг дарга БОАЖГ	Үр дүнтэй арга технологийг хуулбарлан нэвтрүүлнэ.	ААН-ийн хөрөнгө
5.2	Үнсийг барилгын материал, замын дүүргэлт, хөнгөн бетон, дулаалгын материал болгон ашиглах судалгаа хийж, нэвтрүүлэх	2016-2022	БОНХАЖЯ БХБГ БОАЖГ	Байгалийн нөөцийг хэмнэнэ.	Улсын төсөв ОУЗТ
5.3	Хаягдлаар байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг үйлдвэрүүдийг байгуулахыг дэмжих	2016-2022	БОНХАЖЯ БОАЖГ Сумын засаг дарга	Байгалийн нөөцийг хэмнэнэ.	Улсын болон орон нутгийн төсөв
5.4	Хөл газрын хог ургамалтай тэмцэх, энэ хүрээнд хогийн ургамлаар компост хийж органик бордоо үйлвэрлэх арга технологийг дэмжиж түгээн дэлгэрүүлнэ.	2016-2022	БОНХАЖЯ АНЗДТГ	Ургамлын хашлаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.	Улс орон нутгийн төсөв